ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЯВАГДАЖ БАЙНА.

Эрүүл мэндийн яамнаас Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах Олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа үргэлжилж байна.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Журам батлах тухай” А/565 дугаар тушаалаар баталсан журмын дагуу төрийн бус байгууллага, нийгэмлэгүүдээс ирүүлсэн нэр дэвшигчдийн материалын бүрдэлтэй танилцах хурал болон урьдчилсан сонгон шалгаруулалтын ярилцлагыг зохион байгуулсан. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах “Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг”ТББ -ын нэр дэвшигч дараагийн шатанд шалгарсан. Журмын дагуу нэр дэвшүүлэн сонгох хурал 2026 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Эрүүл мэндийн яаман дээр зохион байгуулагдана.